Программ хангамж	2,840.0	1,590.0	(1,250.0)
Бусад биет бус хөрөнгө	178,516.0	136,738.0	(41,778.0)
Дүн	9,746,683.35	5,048,128.6	(4,698,554.7)

Эх сурвалж: Шинэжинст сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,048,128.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,698,554.7 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн шинэчлэлтэй холбоотойгоор Эрүүл мэндийн төв 832,843.7 мянга, Соёлын төвийн 1,505,473.6 мянга, Боловсрол шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газар байгуулагдсантай холбоотойгоор Ерөнхий боловсролын сургууль 1,939,066.9 мянга, Цэцэрлэг 859,926.6 мянга нийт 5,137,310.8 мянган төгрөгийн хөрөнгийг орон нутгаас улсын төсөвт шилжүүлэн бүртгэсэн нь голлох нөлөө үзүүлж байна.

Хүснэгт 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	4,171.3	3,155.3	(1,016.0)	0.1
ЗДТГ	3,006,766.7	3,213,622.8	206,856.1	99.9
ЭМТ	634,295.3		(634,295.3)	0.0
Соёлын төв	1,417,726.5		(1,417,726.5)	0.0
Цэцэрлэг	698,277.9		(698,277.9)	0.0
Сургууль	1,553,375.4		(1,553,375.4)	0.0
Хоршоо хөгжүүлэх сан	440.0	352.0	(88.0)	0.0
Дүн	7,315,053.1	3,217,130.1	(4,097,923.0)	100.0

Эх сурвалж: Шинэжинст сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Тайлант онд нэмэгдсэн 438,756.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн 99.0 хувь буюу 432556.1 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна. Үүнд: Шинэжинст сумын ЗДТГ нь Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газраас 25883.1 мянган төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийг үнэ төлбөргүй, аймгийг Хүнс, хөдөө аж ахуйн газраас 943.9 мянган төгрөгийн өртөг

бүхий тоног төхөөрөмж, Кроунд Гео ХХК-ны хандиваар 168,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий худаг, иргэдээс 2,729.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, сумын ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон 235,000.0 мянган хөрөнгийг тус тус бүртгэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 9. Үндсэн хөрөнгө /мянган төгрөгөөр/

2022 оны эхний үлдэгдэл	9,746,683.4
Нэмэгдсэн	
Худалдан авсан	6,200.0
Бусад	432,556.1
Хасагдсан	
Бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн	5,137,310.8
2022 оны эцсийн үлдэгдэл	3,217,130.1

Эх сурвалж: Шинэжинст сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 4,811.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 925.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл / мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	5,522.3	0.0	(5,522.3)
Байгууллагад төлөх өглөг	214.3	4,811.0	4,596.7
Дүн	5,736.5	4,811.0	(925.5)

Эх сурвалж: Шинэжинст сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Богино хугацаат өр төлбөр нь 4,811.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд Орон нутгийн хөгжлийн сангийн өвс тэжээлтэй холбоотой өглөг 4,811.0 мянган төгрөг байна.

Хүснэгт 11. Өглөгийн дансны үлдэгдэл /мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Эзлэх хувь
Орон нутгийн хөгжлийн сан	0.0	4,811.0	4,811.0	100.0
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	200.0		(200.0)	
Засаг даргын тамгын газар	12.5		(12.5)	
Эмнэлэг	5,459.3		(5,459.3)	
Сургууль	34.7		(34.7)	
Соёлын төв	28.6		(28.6)	
Цэцэрлэг	1.4		(1.4)	
Дүн	5,736.5	4,811.0	(925.5)	100.0

Эх сурвалж: Шинэжинст сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 4,361,526.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,045,665.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 11. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,422,292.4	685,579.3	(1,736,713.1)
Хуримтлагдсан үр дүн	4,191,798.9	3,126,831.4	(1,064,967.5)
Өмнөх үеийн үр дүн	2,807,112.9	7,036,098.6	4,228,985.7
Тайлант үеийн үр дүн	1,384,686.0	(3,909,267.2)	(5,293,953.2)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,793,101.1	549,116.2	(1,243,984.9)
Дүн	8,407,192.3	4,361,526.9	(4,045,665.4)

Эх сурвалж: Шинэжинст сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл үлдэгдэл 4,361,526.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,045,665.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээр буурсантай холбоотой байна.

3.5.11 Орлогын данс

Сумын ИТХ-ын 2021.12.17-ний өдрийн хуралдаанаар 31 дүгээр тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 356.2 мянга, хүү торгуулийн орлогыг 5,000.0 мянга, татварын бус орлогыг 3500.0 мянга нийт 364,700.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт 12. Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
ИОТХ	22,000.0	21,402.2	597.8	97.3
хадгаламжийн хүүгийн орлого	50,000.0	29,912.1	20,087.9	59.8
ҮХЭХ борлуулсны албан татвар	3,000.0	3,400.0	(400.0)	113.3
Бууны татвар	1,200.0	990.0	210.0	82.5
Улсын тэмдэгт	1,500.0	4,575.9	(3,075.9)	305.1
Газрын төлбөр	130,000.0	126,230.4	3,769.6	97.1
Ан агнуур	0	13,721.8	(13,721.8)	
Ус рашаан	0	532.5	(14,964.1)	
Хог хаягдлын үйлчилгээний төлбөр	10,000.0	2,964.8	7,035.2	29.6
ТТАМАТөлбөр	500.0	0	500.0	-
Малын тоо толгойн татвар	36,000.0	26,294.8	9,705.2	73.0
ҮХЭХ-ийн татвар	2,000.0	2,230.4	(230.4)	111.5
Хүү торгууль	5,000.0	13,000.0	(8,000.0)	260.0
ЦХТА орлого /суутган-1/	100,000.0	89,044.9	10,955.1	89.0
Татварын орлого	361,200.0	334,299.8	26,900.2	92.6
Татварын бус орлого	3,500.0	1,680.0	1,820.0	48.0
Нийт орлогын дүн	364,700.00	335,979.80	28,720.20	92.1

Эх сурвалж: Шинэжинст сумын ИТХ-ын тогтоол

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 28720.2 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.

Орлогын нэр төрлөөр авч үзвэл хадгаламжийн хүүгийн орлогыг 20,087.9 мянга, газрын төлбөр 3,769.6 мянга, цалин хөлс түүнтэй адилтгах орлогыг 10,955.1 мянга, малын тоо толгойн албан татвар 9,705.2 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

3.5.12 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71702, 71801, 71802, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 1,206,404.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,700,671.8 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас 780,903.3 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулсан бол 301,358.6 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 2 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021.12.17-ний өдрийн 31 дугаар тогтоолоор нийт 1,700,671.8 мянган төгрөгийг баталсан байна.

Хүснэгт 13. Төсвийн төлөвлөлт

/мянган төгрөгөөр/

Орлогын төрөл	Төсвийн төсөл	Анх батлагдсан төсөв	Зөрүү
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	105,871.2	73,200.9	(32,670.3)
Засаг даргын Тамгын газар	554,882.3	435,855.9	(119,026.4)
Сургууль		129,998.0	129,998.0
Цэцэрлэг		37,971.3	37,971.3
Эрүүл мэндийн төв		29,439.1	29,439.1
Соёлын төв		41,896.5	41,896.5
Сум хөгжүүлэх сан		152,371.4	152,371.4
Орон нутгийн хөгжлийн сан		799,938.7	799,938.7
Нийт дүн	660,753.5	1,700,671.8	1,039,918.3

Эх сурвалж: Шинэжинст сумын ИТХ-ын тогтоол

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2021.12.17-ны өдрийн 31 дүгээр тогтоолоор анх 1,700,671.8 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2022.06.10-ны өдрийн 49 дүгээр тогтоолоор 1,039,918.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Нийт зардлын 361,200.0 мянган төгрөгийг татварын болон татварын бус орлогоор, 542,232.4 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 393,657.2 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 64,500.0 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, уул уурхайн хандив тусламжаар 75,104.2 мянга, урьд оны үлдэгдлээс 263,978.0 мянган төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,082,261.9 мянган төгрөгийн санхүүжилт авч 64,968.4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 14. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	Төвлөрүүлэлт
Засаг даргын Тамгын газар	435,855.9	387,051.0	48,804.9	88.8	45,884.9
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	73,200.9	70,385.0	2,815.9	96.2	2,815.9
Соёлын төв	41,896.5	35,455.2	6,441.3	84.6	6,441.3
Сум хөгжүүлэх сан	152,371.4	100,430.0	51,941.4	65.9	
Сургууль	129,998.0	128,350.0	1,648.0	98.7	1,648.0
Цэцэрлэг	37,971.3	35,109.6	2,861.7	92.5	2,861.7
Эрүүл мэндийн төв	29,439.1	24,122.5	5,316.6	81.9	5,316.6
Орон нутгийн хөгжлийн сан	799,938.7	301,358.6	498,580.1	37.7	-
Нийт дүн	1,700,671.8	1,082,261.9	618,409.9	63.6	64,968.4

Эх сурвалж: Шинэжинст сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл мянган төгрөг буюу 63.6 хувьтай байгаа нь ЗДТГ-ын төсвийг 48,804.9 мянга, ИТХ-ын төсвийг 2815.9 мянга, Ерөнхий боловсролын сургуулийн урсгал зардлыг 1,648.0 мянга, сургуулийн өмнөх боловсролын зардал 2,861.7 мянга, Эрүүл мэндийн төвийн төсвийг 5,316.6 мянга, Соёлын төв 6441.3 мянган төгрөгөөр тус тус зарцуулаагүй нь голлох нөлөөг үзүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн

гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 11,558.0 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогоор 4,595.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 9,568.1 мянган төгрөгийг зарцуулж, 6584.9 мянган төгрөгийн орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 15. Нэмэлт санхүүжилтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	ИТХ	ЗДТГ	НИЙТ
НИЙТ ОРЛОГО	1,300.0	14,853.0	16,153.0
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,300.0	10,258.04	11,558.0
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		4,595.0	4,595.0
Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого			0.0
НИЙТ ЗАРЛАГА	1216.9	8351.2	9568.1
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1216.9	8351.2	9,568.1
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг			0.0
Хөрөнгийн зардал			0.0
Төсөвт төвлөрүүлсэн	83.1	6501.8	6,584.9

Эх сурвалж: Шинэжинст сумын санхүүгийн нэгтгэсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд сумын засаг даргын нөөц санг 25,000.0 мянган төгрөгийг баталж, гүйцэтгэлээр 20,022.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Тус байгууллагын 2022 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Сумын жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан 6 үндсэн зорилтын хүрээнд 46 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 83 хувийн гүйцэтгэлтэй тайлагнажээ.

3.5.5 Аудитын гол асуудал

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 1,700,671.8 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 1,082,261.9 мянган төгрөгийг зарцуулж, 63.6 хувийн биелэлттэй байна.

Тус сум нь 13 нэр төрлийн орлогоор 364,700.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 335,979.8 мянган төгрөгийг төвлөрүүлж, нийт орлого 92.1 хувьтай биелүүлсэн байна.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Шинэжинст сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 2 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 4 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас Шинэжинст сумын Засаг даргын харьяа байгууллагад аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт №16. Төсвийн шууд захирагчийн аудитын дүн

Байгууллагын нэр	Байгууллагын тоо				Аудитын санал дүгнэлтийн төрөл					
	Хамрагдвал зохих	Хамрагдсан	Гүйцэтгэсэн		Бүгд	Үүнээс				
			Бие дааж дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан	
ЗДТГ	1	1			1					
ИТХурал	1	1			1					
ОНХС	1	1			1					
СХС	1	1			1					
НИЙТ ДҮН	4	4			4					

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

Сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 4 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагыг түүвэрт хамруулсан.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 49,960.0 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснийг санхүүгийн тайланд залруулсан байна.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Сумын ЗДТГ	1	49,960.0			1	49,960.0	1	49,960.0		
Дүн	1	49,960.0	1	49,960.0	1	49,960.0	1	49,960.0		

Нийт илэрсэн зөрчлөөс санхүүгийн тайлангийн 11,905.6 мянга, нийцлийн аудитын асуудалтай холбоотой 2,710.4 мянган төгрөгийн зөрчил илэрчээ. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №17. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн

Байгууллагын нэр	Нийт алдаа зөрчлийн дүн		Залруулга		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн зөрчил										
ЗДТГ	6	51,875.8	1	49,960.0	2	2,333.5	3	7106.2		
СТА зөрчлийн дүн	6	51,875.8	1	49,960.0	2	2,333.5	3	7106.2	0	0
СТА-аар шалгасан нийцлийн аудитын асуудал										
ЗДТГ	3	2,710.4			1	244.5	2	2,465.9		
ИТХурал	1	0							1	0
ОНХС	1	0					1	0		
Нийцлийн аудитын дүн	5	2,710.4	0	0	1	244.5	3	2,465.9	1	0

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Шинэжинст сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Нийт дүн 11 62,110.0 1 49,960.0 3 2578.0 6 9572.1 1 0

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн зөрчлийг хүснэгтээр дэлгэрэнгүй харуулбал:

Хүснэгт 18: Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
Харьяа төсвийн байгууллагуудын дүн		62,110.0			
Засаг даргын тамгын газар		62,110.0			
Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл					
1	Шинэжинст сумын ЗДТГ-ын даргын 2022.01.03-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар орон тоо цалингийн санг баталсан бөгөөд тус жагсаалтад биеийн тамирын арга зүйч гэсэн орон тоо байхгүй байхад 1 ажилтныг томилон ТҮ-4-1 шатлалаар буюу 547509 төгрөгөөр 3 дугаар сараас эхлэн сар бүр цалинжуулсан байна	5376.2	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Г.Өлзийбат, Х.Доржсамбуу
2	Засаг даргын нөөц хөрөнгөөс 2022.10.13-ны өдөр иргэн О.Эрдэнэбаттай нохой устгах гэрээ байгуулан 1232.0 мянган төгрөгийг шийдвэргүйгээр олгосон байна. Мөн ХХОАТ 10 хувийг суутган тооцоогүй байна. Мөн Засаг даргын 2022.11.07-ны өдрийн А/109 дүгээр захирамжаар 5 иргэнд олгосон нэг удаагийн мөнгөн тэтгэмжээс хуулийн дагуу ХХОАТ суутгаагүй байна.	173.2	Төлбөрийн акт тогтоосон	Дарга, нягтлан бодогч	Г.Өлзийбат, Х.Доржсамбуу
3	Байгууллагын даргын 2022.12.12-ны өдрийн А/27 дугаар тушаалаар томилогдсон эд хөрөнгийн жилийн эцсийн тооллого явуулах ажлын хэсэг нь 2022 оны жилийн эцсийн 1730.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 98260.2 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгийг тоолоогүй, нягтлан бодогч, тооцоо бодсон акт үйлдээгүй, мөн байгууллагын өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлээгүй, дүгнэлт гараагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалтыг зөрчиж байна.	1730.0	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Г.Өлзийбат, Х.Доржсамбуу
4	Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтыг тулгахад хувь хүмүүс болон байгууллагад олгосон тэтгэмж, дэмжлэгт 2.5 хувь, шагнал урамшуулал, тэмцээн уралдаанд 59.9 хувь, нохой устгал болон мал эмнэлгийн үйлчилгээнд 10.8 хувь, бусад үйл ажиллагаанд 26.9 хувь нийт 20022.7 мянган төгрөгийг зарцуулсан байгаа нь нийт батлагдсан төсвийн 78.2 хувийг эзэлж байна. Тус сум нь байгалийн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс шалтгаалсан гамшигт үзэгдэл болон халдварт өвчин, аюул осол тохиолдоход авах арга хэмжээг санхүүжүүлэхэд бэлэн биш байгааг харуулж байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 3.4 дэх заалтыг зөрчиж байна.	0	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Г.Өлзийбат, Х.Доржсамбуу
5	Шатахууны зардлаас 2160.3 мянган төгрөгийн шатахууныг зориулалт бусаар зарцуулсан байна.	2160.3	Төлбөрийн акт тогтоосон	Дарга, нягтлан бодогч	Г.Өлзийбат, Х.Доржсамбуу
	Дүн	11,905.6			
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал					
1	Бичиг хэргийн зардлаас 244.5 мянган төгрөгийг зэвсэгт хүчний 101 жилийн ойн баярыг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотойгоор медаль өргөмжлөл худалдан авсан байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дахь заалтыг зөрчиж байна.	244.5	Төлбөрийн акт тогтоосон	Дарга, нягтлан бодогч	Г.Өлзийбат, Х.Доржсамбуу
2	Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хуулийн 6.4.5-д заасан орлогын 5000.0 мянган төгрөгийн 1 гүйлгээ, зарлагын 70685.9 мянган төгрөгийн 5 гүйлгээг мэдээлээгүй, мөн бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын гэрээг байршуулаагүй байна.	0	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	М.Чинбат, Г.Түмэнболд
3	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2-д заасны дагуу горим сорил хэрэгжүүлэхэд өмнөх оноос бичиг хэргийн зардлыг 6.5 хувь, тээвэр шатахууны зардлыг 9.1 хувиар нэмэгдүүлсэн байна.	2465.9	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Г.Өлзийбат, Х.Доржсамбуу
	Дүн	2,710.4			

Шинэжинст сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
Иргэдийн төлөөлөгчдийн хурал		0			
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал					
1	Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 5,735,900 мянган төгрөгийн 1 гүйлгээ, зарлагын 6,313,200 мянган төгрөгийн 1 гүйлгээг дутуу мэдээлсэн байна. Мөн гэрэл цахилгаан, цэвэр бохир ус нийлүүлэх гэрээнүүдийг байршуулаагүй	0	Зөвлөмж хүргүүлсэн.	Дарга, нягтлан бодогч	Т.Цэнгэлмаа, Х.Доржсамбуу
Дүн		0			
Орон нутгийн хөгжлийн сан		0			
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал					
1	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг гүйцэтгэх иргэн аж ахуйн нэгжийн гэрээг Шилэн дансны цахим хуудаст барйшуулаагүй байна.	0	Албан шаардлага өгсөн.	Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Б.Бат-Эрдэнэ, Х.Дагважав
Дүн		0			

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

3.5.6 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 8 хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр нийт 1,700,671.8 мянган төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 1,082,261.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 15. Төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,700,671.8	1,082,261.9	618,409.9	63.6
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	384,794.2	342,886.9	41,907.3	89.1
70105 ОН-ын өөрөө удирд ёсны байгууллага	66,887.7	64,071.8	2,815.9	95.8
70106 ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	317,906.5	278,815.1	39,091.4	87.7
80106 Баг, хорооны ҮАЗардал	53,192.0	50,605.8	2,586.2	95.1
70106 ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	53,192.0	50,605.8	2,586.2	95.1
80112 Нийтлэг үйлчилгээ	239,304.9	223,037.3	16,267.6	93.2
71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	29,439.1	24,122.5	5,316.6	81.9
71702 Соёл урлаг	41,896.5	35,455.2	6,441.3	84.6
71801 Сургуулийн өмнөх боловсрол	37,971.3	35,109.6	2,861.7	92.5
71802 Ерөнхий боловсрол	129,998.0	128,350.0	1,648.0	98.7
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	18,535.4	16,985.4	1,550.0	91.6
70106 ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	18,535.4	16,985.4	1,550.0	91.6
80815 Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөг	26,335.2	26,335.2	0.0	100.0
70105 ОН-ын өөрөө удирд ёсны байгууллага	6,313.2	6,313.2	-	100.0
70106 ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	20,022.0	20,022.0	0.0	100.0
80904 Нийгмийн зориулалттай барилга	221,706.5	90,856.3	130,850.2	41.0
70503 Орон нутгийн зорилтот ХОруулалт	221,706.5	90,856.3	130,850.2	41.0
81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	25,600.0	20,022.7	5,577.3	78.2
70106 ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	25,600.0	20,022.7	5,577.3	78.2
82212 Хур хог хаягдал, орчны бохирдл	600.0	600.0	-	100.0
70106 ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	600.0	600.0	-	100.0
82611 Жижиг дунд үйлдвэрийг дэмжих	152,371.4	100,430.0	51,941.4	65.9
72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	152,371.4	100,430.0	51,941.4	65.9
83401 ОНХС - Итгэлцүүрээр олгох	284,714.9	102,701.7	182,013.2	36.1
70503 Орон нутгийн зорилтот ХОруулалт	284,714.9	102,701.7	182,013.2	36.1
83402 ОНХС - Хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	21,742.4	-	21,742.4	0.0
70503 Орон нутгийн зорилтот ХОруулалт	21,742.4	-	21,742.4	0.0
83403 ОНХС - Ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	192,519.6	50,691.6	141,828.0	26.3
70503 Орон нутгийн зорилтот ХОруулалт	192,519.6	50,691.6	141,828.0	26.3
83405 ОНХС - Малын тоо толгойн албан татвар	36,000.0	23,160.0	12,840.0	64.3
70503 Орон нутгийн зорилтот ХОруулалт	36,000.0	23,160.0	12,840.0	64.3
83406 ОНХС - Бусад	43,255.3	33,949.0	9,306.3	78.5
70503 Орон нутгийн зорилтот ХОруулалт	43,255.3	33,949.0	9,306.3	78.5

Эх сурвалж: Шинэжинст сумын Засаг даргын нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Шинэжинст сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цээням, дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 12-ний өдрийн 1/11 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,800,315.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 42,004.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 29,403.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус сумын хөрөнгө оруулалтын төсөв, төлөвлөгөөнд захиргааны зориулалттай шинээр байшин барилга тусгаагүй байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 “Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл болон бусад шалтгаанаар ашиглах боломжгүй болохыг тогтоосон тухай эрх бүхий байгууллагын дүгнэлт, шийдвэр гарснаас бусад тохиолдолд захиргааны зориулалтаар барилга шинээр барихыг хориглоно” гэсэн заалттай нийцэж байна.

Шинэжинст сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Засаг даргын тамгын газар нь бичиг хэргийн зардлаас 244.5 мянган төгрөгийг зэвсэгт хүчний 101 жилийн ойн баярыг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотойгоор медаль өргөмжлөл худалдан авсан байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дахь заалтыг зөрчсөн тул төлбөрийн акт тогтоосон.
2. Өмнөх оноос бичиг хэргийн зардлыг 6.5 хувь, тээвэр шатахууны зардлыг 9.1 хувиар нэмэгдүүлсэн тул албан шаардлага хүргүүлсэн.

4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих 155 мэдээллээс тухай бүр мэдээлэх мэдээллээс 23, сар бүр мэдээлэх мэдээллээс 19 мэдээллийг хугацаа хоцроож, улирал бүр мэдээлэх мэдээллээс 8, хагас жилд нэг удаа мэдээлэх мэдээллээс 1 мэдээллийг хугацаа хоцроосон, мөн "Корунд гео"ХХК-тай байгуулсан "Орон нутгийн хөгжлийн дэмжих, хамтран ажиллах" 100,000.0 мянган төгрөгийн гэрээ, "Эрдэнэ монгол" ХХК, түүний охин компани болох "Лидер эсплорэйшн" ХХК, "Аниан ресориз"-тай байгуулсан "Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах үйлдвэр байгуулахдаа холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай" 1,500.000,0 мянган төгрөгийн гэрээ, шатахуун, өвс тэжээл худалдан авах гэрээ, хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээлийн шийдвэр зэрэг 248,800.0 мянган төгрөгийн мэдээллийг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Хүснэгт 16. Шилэн дансны мэдээлэл

дд	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд нь мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй мэдээлэл
1	Бүтэн жил	12	12	12	0	
2	Хагас жил	3	3	2	1	
3	Улирал бүр	2	8	0	8	
4	Сар бүр	5	60	41	19	
5	Тухай бүр	6	72	49	23	
Нийт дүн		28	155	104	51	

Эх сурвалж: Шилэн дансны цахим хуудас

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь бүрэн байршуулах зөвлөмжийг хүргүүлж байна.

4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.7.1 Завсрын аудитын талаар

Тайлант хугацаан завсрын аудит хийгээгүй болно.

4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 8,909.6 мянган төгрөгийн 5 зөвлөмж хүргүүлсэн ба зөвлөмжийн хэрэгжилтийг сумын Засаг даргын 2022 оны 07дүгээр сарын 21-ний өдрийн 2/6 тоот албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна.

Хүснэгт 16. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	5	8,909.6	5	8,909.6	0	0	100
Нийт	5	8,909.6	5	8,909.6	0	0	100

Эх сурвалж: Шийдвэрийн хэрэгжилт

4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хандив тусламж, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдлыг завсрын аудитаар тодруулж үзэх шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 9303.0 мянган төгрөгийн 4 зөрчил² илэрснээс 9303.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага 1, алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

5.1 Албан шаардлага

5.2.1 Малын тоо толгойн албан татварыг 36,000.0 мянган төгрөгөөр төлөвлөснөөс тайлант онд гүйцэтгэлээр 26,697.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн ба орон нутгийн орлогод төвлөрсөн татварын орлогыг хууль журмын дагуу сумын ОНХС-д төвлөрүүлсэн байна.

Харин татварын байцаагчийн ногдуулсан 36,000.0 мянган төгрөгөөс 9,303.0 мянган төгрөгийн орлогыг орон нутагт бүрэн төвлөрүүлээгүй байна

Энэ нь Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 “Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төсөвт төлнө”, Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8 “Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ”, 23.8.15 “Малын тоо толгойн албан татвар” гэсэн заалтуудыг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлээгүй 243 иргэний 9,303.0 мянган төгрөгийн малын тоо толгойн албан татварыг төсөвт бүрэн төвлөрүүлэх албан шаардлагыг хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт: Сумын төсөвт төвлөрөх татварын орлогоос газрын төлбөр 3,769.6 мянга, хог хаягдлын үйлчилгээний төлбөр 7,035.2, малын тоо толгойн албан татварын орлого 9,303.0 мянган төгрөгөөр тасарсан байна.

Өгсөн зөвлөмж:

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг бүрэн төвлөрүүлж ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.

2. Хууль журмын хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих 155 мэдээллээс тухай бүр мэдээлэх мэдээллээс 23, сар бүр мэдээлэх мэдээллээс 19 мэдээллийг хугацаа хоцроож, улирал бүр мэдээлэх мэдээллээс 8, хагас жилд нэг удаа мэдээлэх мэдээллээс 1 мэдээллийг хугацаа хоцроосон, мөн "Корунд гео"ХХК-тай байгуулсан "Орон нутгийн хөгжлийн дэмжих, хамтран ажиллах" 100,000.0 мянган төгрөгийн гэрээ, "Эрдэнэ монгол" ХХК, түүний охин компани болох "Лидер эсплорэйшн" ХХК, "Аниан ресориз"-тай байгуулсан "Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах үйлдвэр байгуулахдаа холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай" 1,500.000,0 мянган төгрөгийн гэрээ, шатахуун, өвс тэжээл худалдан авах гэрээ, хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээлийн шийдвэр зэрэг 248,800.0 мянган төгрөгийн мэдээллийг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь бүрэн байршуулах.

2. Дотоод хяналт хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Шинэжинст сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт сул байгаагаас жилийн эцсээр хөрөнгийг дутуу тоолсон, тооллогын дүнг өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлээгүй, засаг даргын нөөц хөрөнгийг урамшуулал, дэмжлэг, сургалт семинарт хавтгайруулан зарцуулсан, шатахууныг зориулалт бусаар зарцуулсан, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй зэрэг зөрчилд нийт 62,110.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 49,960.0 мянган төгрөгийн 1 алдааг санхүүгийн тайланд залруулж, 2578.0 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 9,572.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 6 албан шаардлага, алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 1 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Өгсөн зөвлөмж:

Харьяа төсөвт байгууллагуудын санхүү төсвийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, хариуцлагыг дээшлүүлэх, төсвийн сахилга батыг дээшлүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шинэжинст сумын Засаг дарга	3	9303.0			1	9303.0	2	0				
Дүн	3	9303.0			1	9303.0	2	0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шинэжинст сумын Засаг дарга	1	0						1	0
Дүн	1	0						1	0